# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨС ВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

**АУДИТЫН КОД: САГ-2019/4/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер Я.Самбууням**
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn
**Аудитор Б.Долгоржав**
Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн**
**“Дөлгөөнхайрхан уул аудит” ХХК**
Утас: 70005711 Цахим хаяг: dulguunhairhan_audit@mongol.net


Улаанбаатар хот

# ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
# 2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ ........ 2
2 Аудитын тайлан ........ 4
2.1. Оршил ........ 4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 9
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 9
2.11. Шилэн дансны мэдээлэл ........ 9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........ 9
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 10
3 Менежментийн захидал ........ 11
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 20
4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан ........ 22
5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ 23

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/316
танай ____________-ны № ____________-т

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГА
Д.НЯМХҮҮ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



070772
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дарга Д.Нямхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 04-нөөс 2019 оны 02 дугаар сарын 22–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК-ийн аудитор Н.Янжмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/91 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Халдварт өвчний тархалтыг тандан судлах, халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, оношлогоо эмчилгээ, тусламж үйлчилгээг олон улсын стандартын түвшинд үе шаттайгаар хэрэгжүүлэх, халдварт өвчний үүсгэгчийг лабораториар баталгаажуулах

Үйл ажиллагааны чиглэл:

Эрүүл мэндийн яамны сайдын тушаалаар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үндэсний бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
2. Тусламж үйлчилгээний чанар, хүртээмжтэй нягт уялдуулан санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх;
3. Улсын хэмжээнд цахим эмнэлгийн сүлжээ, алсын зайн удирдлага арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх;
4. Багаар хамтран ажиллах;
5. Нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа дэвшилтэд технологийг эмчилгээ оношилгоонд нэвтрүүлэх;
6. Бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх;

7. Аймаг, нийслэлийн түвшинд халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
8. Эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын бодлого, тогтолцоог бэхжүүлэх;
9. Вируст гепатит өвчнийг хяналтанд авах, вируст гепатиттай тэмцэх, сэргийлэх үндэсний дэд хөтөлбөр хэрэгжүүлэх;
10. Гэдэсний халдвараас сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, өнөөгийн тогтолцоог бэхжүүлэх;
11. Зоонозын халдвараас сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, өнөөгийн тогтолцоог бэхжүүлэх

гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны хувьд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

**2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр

батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлтийг тусгасан нь нийцсэн байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул томилогдсон баг аудитыг гүйцэтгэлээ.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Халдварт өвчин судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 13 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тухайн байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц гэж үзсэнтэй холбоотой юм.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 31,423,360.1 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 314,233.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 10 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг B501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 31,136.0 | |
| 2 | Албан шаардлага өгсөн | 1 | 34,292.9 | |
| | Дүн | 2 | 65,428.9 | |

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

<u>2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал</u>

Тайлант онд нийт ажилтны ээлжийн амралтын олговрыг тооцохдоо цалин хөлсний дүнд хоол унааны хөнгөлөлтийг оруулж тооцсноос 31,136.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 2 дугаар хавсралт "Ээлжийн амралтын олговор тооцох журам", Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ыг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн:</u>

Төлбөрийн акт тогтоох

<u>2.8.1.2 Балансын данстай холбоотой асуудал</u>

413,703.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэнээс бусад зардлын тооцооны авлага 34,292.9 мянган төгрөгийг тооцоо хийж баталгаажуулаагүй, барагдуулаагүй олон жил дамжсан байна.

Энэ нь Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх гэснийг зөрчсөн байна.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Шийдвэрлэсэн:

Албан шаардлага өгөх

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Цалингийн зардал дээр амралтын мөнгөний тооцоолол зассан эсэх, бараа материалын дансны анхан шатны баримтын бүрдэл, авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажилласан эсэх талаар үзнэ.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал үгүй байна.

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 19,798,105.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 19,798,788.1 мянган төгрөг буюу 97.32 хувьтай байгаа нь нийт зардлаас 23,078.1 мянган төгрөг хэмнэсэн ба байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 53.0 мянга, бусад урсгал шилжүүлэг 23,025.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой.

Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас олох орлогоо 37,870.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих орлого 37,186.9 мянган төгрөгөөр буурсан байна.

**2.11. Шилэн дансны мэдээлэл**

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

**2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд орших буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Батлагдсан төсвийг ангилалаас зөрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл. 5.5, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Зардлыг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулсан эсэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал “Эдийн засгийн ангилал батлах тухай” гэснийг мөрдөж төлөвлөгөөг зөв зохистой хийх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн. Сангийн яам, Эрүүл мэндийн яаманд төсвийг бодит хэрэгцээнд үндэслэн батлуулах хүсэлтийг уламжилна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,163,008,222.90** | **12,155,224,273.02** |
| **33** | **АВЛАГА** | 233,393,300.00 | 413,703,716.79 |
| **335** | **Бусад авлага** | 233,393,300.00 | 413,703,716.79 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 233,393,300.00 | 413,703,716.79 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 7,929,614,922.90 | 11,741,520,556.23 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,702,131,862.81 | 10,050,211,398.13 |
| 35130 | Эм боох материал | 6,702,131,862.81 | 10,050,211,398.13 |
| **354** | **Хангамжийн материал** | 1,227,423,060.09 | 1,691,309,158.10 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,060,946.50 | 3,297,964.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 925,843,143.74 | 1,423,234,997.05 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,328,200.00 | 11,929,850.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,397,000.00 | 200,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 26,922,366.67 | 26,471,451.57 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 256,871,403.18 | 226,174,895.48 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **12,531,073,829.18** | **50,614,150,923.89** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12,531,073,829.18 | 50,614,150,923.89 |
| **392** | **Биет хөрөнгө** | 12,526,634,940.14 | 39,988,417,923.89 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 19,906,688,928.00 | 36,368,655,921.94 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -10,909,009,214.87 | -6,975,290.21 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,205,169,054.00 | 1,283,024,088.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -981,686,054.40 | -1,196,555,638.34 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 8,745,196,313.82 | 10,609,599,001.11 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -5,955,520,330.36 | -7,437,413,086.95 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 991,912,836.47 | 994,735,234.65 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -677,130,219.05 | -702,384,812.61 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 237,315,782.00 | 75,695,262.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -44,144,852.78 | -7,610,405.90 |
| 39217 | Ном | 7,842,697.31 | 7,647,650.20 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 4,438,889.04 | 10,625,733,000.00 |
| 39301 | Програм хангамж | 10,774,750.00 | 10,774,750.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -6,335,860.96 | -7,249,750.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө /газар/ | 00.00 | 10,622,208,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **20,694,082,052.08** | **62,769,375,196.91** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **22,567,948.65** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 22,567,948.65 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 22,567,948.65 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **20,671,514,103.43** | **62,769,375,196.91** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 20,671,514,103.43 | 62,769,375,196.91 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 9,674,240,769.60 | 20,296,448,769.60 |
| 51101 | Өмч: - төрийн | 9,674,240,769.60 | 20,296,448,769.60 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,549,479,911.44 | 8,295,778,856.28 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,413,085,360.34 | 4,556,327,643.28 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -2,863,605,448.91 | 3,739,451,212.99 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 6,447,793,422.40 | 34,177,147,571.03 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **20,694,082,052.08** | **62,769,375,196.91** |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **31,449,497,114.84** | **35,162,811,745.35** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,015,914,253.16** | **14,035,590,355.86** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12,015,914,253.16 | 14,035,590,355.86 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,015,914,253.16 | 14,035,590,355.86 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 155,603,803.01 | 171,053,055.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 25,978,415.04 | 36,816,945.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 11,834,332,035.11 | 13,827,720,355.86 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **19,433,582,861.68** | **21,127,221,389.49** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 16,769,309,900.00 | 18,513,147,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 16,769,309,900.00 | 18,513,147,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,649,611,761.68 | 1,536,303,261.49 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,498,299,773.68 | 1,130,584,439.49 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 69,646,281.00 | 251,857,100.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 81,665,707.00 | 153,861,722.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,014,661,200.00 | 1,077,770,628.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,014,661,200.00 | 1,077,770,628.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **20,896,057,088.78** | **20,907,403,335.52** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **20,896,057,088.78** | **20,907,403,335.52** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 20,635,611,139.79 | 20,489,711,087.52 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 10,230,101,045.76 | 10,343,820,184.92 |
| 210101 | Үндсэн цалин | 10,019,345,869.76 | 10,057,589,228.42 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 34,396,265.00 |
| 210104 | Урамшуулал | 210,755,176.00 | 251,834,691.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 933,493,879.89 | 1,286,849,601.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 587,489,051.60 | 796,802,136.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 82,520,924.02 | 99,600,266.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 81,648,727.48 | 176,571,841.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 16,521,770.71 | 19,408,413.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 165,313,406.08 | 194,466,943.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 983,978,820.00 | 829,068,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 357,537,094.00 | 328,751,032.91 |
| 210302 | Түлш, халаалт | 315,289,406.00 | 288,679,126.28 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 284,446,400.00 | 211,638,540.81 |
| 210304 | Байрны түрээс | 26,705,920.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 659,285,531.25 | 693,278,724.07 |
| 210401 | Бичиг хэрэг | 145,994,056.65 | 98,142,728.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 300,281,369.00 | 250,830,394.75 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨВШИЛГҮЙ

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 24,657,705.74 | 17,392,977.96 |
| 210404 | Ном, хэвлэл | 19,735,000.00 | 14,864,990.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 58,247,815.50 | 48,888,139.42 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 109,372,721.36 | 263,159,493.44 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 996,863.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5,508,526,010.92 | 5,050,203,601.05 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,735,331,772.96 | 4,282,225,315.95 |
| 210502 | Хоол, хүнс | 773,119,237.96 | 767,678,285.10 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 75,000.00 | 300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 227,052,848.00 | 113,941,877.86 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,014,480.00 | 9,933,890.00 |
| 210602 | Тавилга | 3,905,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 12,008,850.00 | 8,655,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 199,124,518.00 | 95,352,687.86 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 298,597,250.00 | 245,848,687.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 44,940,200.00 | 41,468,835.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 253,657,050.00 | 204,379,852.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 271,425,403.00 | 397,531,207.99 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 255,963,485.00 | 378,639,297.99 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,872,148.00 | 8,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,057,270.00 | 337,610.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,160,900.00 | 2,182,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8,371,600.00 | 8,371,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,523,150,350.97 | 1,529,168,503.49 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,417,160.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,512,733,190.97 | 1,529,168,503.49 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 260,445,948.99 | 417,692,248.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 205,155,446.00 | 391,644,367.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 205,155,446.00 | 382,644,367.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 9,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 55,290,502.99 | 26,047,881.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,290,502.99 | 26,047,881.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **10,553,440,026.06** | **14,255,408,409.83** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 13,417,045,474.97 | 10,515,957,196.83 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 21,394,594.13 | 9,653,682.08 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 13,395,650,880.84 | 10,247,946,847.05 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 258,356,667.70 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -13,417,045,474.97 | -10,515,957,196.83 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-2,863,605,448.91** | **3,739,451,213.00** |

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **19,734,480,337.73** | **21,534,191,789.49** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **170,504,917.05** | **207,870,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 170,504,917.05 | 207,870,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 170,504,917.05 | 207,870,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 155,603,803.01 | 171,053,055.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,901,114.04 | 36,816,945.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **19,563,975,420.68** | **21,326,321,789.49** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 16,769,309,900.00 | 18,513,147,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 16,769,309,900.00 | 18,513,147,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,780,004,320.68 | 1,735,403,661.49 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,498,299,773.68 | 1,329,684,839.49 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,038,840.00 | 251,857,100.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 81,665,707.00 | 153,861,722.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,014,661,200.00 | 1,077,770,628.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,014,661,200.00 | 1,077,770,628.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **19,621,290,837.73** | **21,514,365,789.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **19,621,290,837.73** | **21,514,365,789.49** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **18,937,944,488.74** | **20,727,627,031.49** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 9,760,697,476.00 | 10,315,374,591.50 |
| 210101 | Үндсэн цалин | 6,219,385,500.00 | 5,479,748,600.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,703,241,000.00 | 2,998,674,600.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 703,790,200.00 | 703,790,200.00 |
| 210104 | Урамшуулал | 1,134,280,776.00 | 1,133,161,191.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,145,453,200.00 | 1,289,368,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,145,453,200.00 | 803,072,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 97,259,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 175,066,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 19,451,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 194,518,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 983,978,820.00 | 829,068,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 357,537,094.00 | 328,751,032.91 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 315,289,406.00 | 288,679,126.28 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 284,446,400.00 | 211,638,540.81 |
| 210304 | Байрны түрээс | 26,705,920.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 586,819,912.56 | 516,560,321.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 116,705,355.00 | 68,428,181.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 297,906,663.00 | 250,810,548.75 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 26,080,534.56 | 17,190,485.96 |
| 210404 | Ном, хэвлэл | 19,735,000.00 | 14,864,990.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 110,949,800.00 | 111,249,615.29 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,442,560.00 | 54,016,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5,675,241,740.00 | 6,864,937,802.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,814,068,870.00 | 6,005,420,990.00 |
| 210502 | Хоол, хүнс | 764,900,820.00 | 776,069,712.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 96,272,050.00 | 83,447,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 157,250,296.00 | 186,253,562.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 37,363,393.00 | 48,951,240.00 |
| 210602 | Тавилга | 13,905,000.00 | 32,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,777,800.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 102,204,103.00 | 105,302,322.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 295,977,050.00 | 245,848,687.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 41,400,000.00 | 41,468,835.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 254,577,050.00 | 204,379,852.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 332,525,994.18 | 480,215,067.99 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 293,412,976.18 | 437,039,067.99 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,221,318.00 | 8,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,108,800.00 | 1,368,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,160,900.00 | 2,182,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 269,300.00 | 272,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8,371,600.00 | 8,371,600.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 22,981,100.00 | 22,981,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **683,346,348.99** | **786,738,758.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 428,955,446.00 | 389,644,367.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 205,155,446.00 | 380,644,367.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 223,800,000.00 | 9,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 254,390,902.99 | 397,094,391.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 254,390,902.99 | 397,094,391.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **113,189,500.00** | **19,826,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **113,189,500.00** | **19,826,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **113,189,500.00** | **19,826,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 113,189,500.00 | 19,826,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 113,189,500.00 | 19,826,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-113,189,500.00** | **-19,826,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан:

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **9,674,240,769.60** | **6,447,793,422.40** | **7,413,085,360.34** | **23,535,119,552.34** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | -2,863,605,448.91 | -2,863,605,448.91 |
| **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | | |
| **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **9,674,240,769.60** | **6,447,793,422.40** | **4,549,479,911.44** | **20,671,514,103.44** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 6,847,731.85 | 6,847,731.85 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **9,674,240,769.60** | **6,447,793,422.40** | **4,556,327,643.28** | **20,678,361,835.28** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 10,622,208,000.00 | 27,729,354,148.63 | 00.00 | 38,351,562,148.63 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | 3,739,451,212.99 | 3,739,451,212.99 |
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **20,296,448,769.60** | **34,177,147,571.03** | **8,295,778,856.28** | **62,769,375,196.91** |

## 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан:

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 19,798,105,000.00 | 19,775,026,867.00 | -23,078,133.00 | 99.88 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 19,798,105,000.00 | 19,775,026,867.00 | -23,078,133.00 | 99.88 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 19,394,435,500.00 | 19,394,382,500.00 | -53,000.00 | 99.99 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 10,065,009,600.00 | 10,065,009,600.00 | 00.00 | 100 |
| Үндсэн цалин | 5,479,748,600.00 | 5,479,748,600.00 | 00.00 | 100 |
| Нэмэгдэл | 2,998,674,600.00 | 2,998,674,600.00 | 00.00 | 100 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 703,790,200.00 | 703,790,200.00 | 00.00 | 100 |
| Урамшуулал | 882,796,200.00 | 882,796,200.00 | 00.00 | 100 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,289,368,300.00 | 1,289,368,300.00 | 00.00 | 100 |
| Тэтгэврийн даатгал | 803,072,800.00 | 803,072,800.00 | 00.00 | 100 |
| Тэтгэмжийн даатгал | 97,259,100.00 | 97,259,100.00 | 00.00 | 100 |
| ҮОМШӨ-ний даатгал | 175,066,400.00 | 175,066,400.00 | 00.00 | 100 |
| Ажилгүйдлийн даатгал | 19,451,800.00 | 19,451,800.00 | 00.00 | 100 |
| Эрүүл мэндийн даатгал | 194,518,200.00 | 194,518,200.00 | 00.00 | 100 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 829,121,700.00 | 829,068,700.00 | -53,000.00 | 99.99 |
| Гэрэл, цахилгаан | 328,771,900.00 | 328,751,032.91 | -20,867.09 | 99.99 |
| Түлш, халаалт | 288,703,400.00 | 288,679,126.28 | -24,273.72 | 99.99 |
| Цэвэр, бохир ус | 211,646,400.00 | 211,638,540.81 | -7,859.19 | 99.99 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 269,240,100.00 | 269,240,100.00 | 00.00 | 100 |
| Бичиг хэрэг | 11,856,100.00 | 12,137,840.00 | 281,740.00 | 102.38 |
| Тээвэр, шатахуун | 81,257,800.00 | 79,304,069.75 | -1,953,730.25 | 97.60 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,426,800.00 | 12,532,074.96 | 2,105,274.96 | 120.19 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 112,049,800.00 | 111,249,615.29 | -800,184.71 | 99.29 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 53,649,600.00 | 54,016,500.00 | 366,900.00 | 100.68 |
| **Нормативт зардал** | 6,544,122,700.00 | 6,544,122,700.00 | 00.00 | 100 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,862,792,700.00 | 5,862,792,700.00 | 00.00 | 100 |
| Хоол, хүнс | 597,882,900.00 | 597,882,900.00 | 00.00 | 100 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 83,447,100.00 | 83,447,100.00 | 00.00 | 100 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 128,468,600.00 | 128,468,600.00 | 00.00 | 100 |
| Багаж, техник, хэрэгсэл | 57,740,000.00 | 57,740,000.00 | 00.00 | 100 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | | |
|---|---|---|---|---|
| Урсгал засвар | 70,728,600.00 | 70,728,600.00 | 00.00 | 100 |
| **Томилолт, зочны зардал** | 3,116,500.00 | 3,116,500.00 | 00.00 | 100 |
| Дотоод албан томилолт | 3,116,500.00 | 3,116,500.00 | 00.00 | 100 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 265,988,000.00 | 265,988,000.00 | 00.00 | 100 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 222,812,000.00 | 222,812,000.00 | 00.00 | 100 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 8,000,000.00 | 8,000,000.00 | 00.00 | 100 |
| Даатгалын үйлчилгээ | 1,368,600.00 | 1,368,600.00 | 00.00 | 100 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 2,182,700.00 | 2,182,700.00 | 00.00 | 100 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 272,000.00 | 272,000.00 | 00.00 | 100 |
| Газрын төлбөр | 8,371,600.00 | 8,371,600.00 | 00.00 | 100 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 22,981,100.00 | 22,981,100.00 | 00.00 | 100 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 403,669,500.00 | 380,644,367.00 | -23,025,133.00 | 94.30 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 403,669,500.00 | 380,644,367.00 | -23,025,133.00 | 94.30 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 403,669,500.00 | 380,644,367.00 | -23,025,133.00 | 94.30 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 19,798,105,000.00 | 19,798,788,128.00 | 683,128.00 | 99.99 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 18,513,147,500.00 | 18,513,147,500.00 | 00.00 | 100 |
| Улсын төсвөөс санхүүжих | 18,513,147,500.00 | 18,513,147,500.00 | 00.00 | 100 |
| **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,114,957,500.00 | 1,077,770,628.00 | -37,186,872.00 | 96.66 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,114,957,500.00 | 1,077,770,628.00 | -37,186,872.00 | 96.66 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 170,000,000.00 | 207,870,000.00 | 37,870,000.00 | 122.28 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 104,000,000.00 | 171,053,055.00 | 67,053,055.00 | 164.47 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 66,000,000.00 | 36,816,945.00 | -29,183,055.00 | 55.78 |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 00.00 | 100 |
| Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 00.00 | 100 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 748.00 | 748.00 | 00.00 | 100 |
| Удирдах ажилтан | 07.00 | 07.00 | 00.00 | 100 |
| Гүйцэтгэх ажилтан | 495.00 | 495.00 | 00.00 | 100 |
| Үйлчлэх ажилтан | 246.00 | 246.00 | 00.00 | 100 |

## 4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан:

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,735,403,661.49** | **-1,735,403,661.49** | |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,735,403,661.49** | **-1,735,403,661.49** | |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,353,070,531.49 | -1,353,070,531.49 | |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 250,364,991.50 | -250,364,991.50 | |
| Урамшуулал | 250,364,991.50 | -250,364,991.50 | |
| **Хангамж, бараа материалын зардал** | 247,320,221.00 | -247,320,221.00 | |
| Бичиг хэрэг | 56,290,341.00 | -56,290,341.00 | |
| Тээвэр, шатахуун | 171,506,479.00 | -171,506,479.00 | |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,658,411.00 | -4,658,411.00 | |
| Ном, хэвлэл | 14,864,990.00 | 14,864,990.00 | |
| **Нормативт зардал** | 320,815,102.00 | -320,815,102.00 | |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 142,628,290.00 | -142,628,290.00 | |
| Хоол, хүнс | 178,186,812.00 | -178,186,812.00 | |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 77,610,962.00 | -77,610,962.00 | |
| Багаж, техник, хэрэгсэл | 11,037,240.00 | -11,037,240.00 | |
| Тавилга | 32,000,000.00 | -32,000,000.00 | |
| Урсгал засвар | 34,573,722.00 | -34,573,722.00 | |
| **Томилолт, зочны зардал** | 242,732,187.00 | -242,732,187.00 | |
| Гадаад албан томилолт | 41,468,835.00 | -41,468,835.00 | |
| Дотоод албан томилолт | 201,263,352.00 | -201,263,352.00 | |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 214,227,067.99 | -214,227,067.99 | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 214,227,067.99 | -214,227,067.99 | |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 382,333,130.00 | -382,333,130.00 | |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,000,000.00 | -9,000,000.00 | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 373,333,130.00 | -373,333,130.00 | |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,735,403,661.49** | **-1,735,403,661.49** | |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,735,403,661.49** | **-1,735,403,661.49** | |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,329,684,839.49 | -1,329,684,839.49 | |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 251,857,100.00 | -251,857,100.00 | |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 153,861,722.00 | -153,861,722.00 | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: | Аудитын нэр: | ***Халдварт өвчин судлалын үндэсний төв 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: |
| ***2019.02.25*** | | | САГ-2019/4/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | ***Халдварт өвчин судлалын үндэсний төв*** | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | Тайлант онд нийт ажилтны ээлжийн амралтын олговрыг тооцохдоо цалин хөлсний дүнд хоол унааны хөнгөлөлтийг оруулж тооцсоноос 31,136.0 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 31,136.00 | Төлбөрийн акт тогтоох | Санхүүгийн албаны дарга | Г.Хунзаяа |
| 2 | Бусад зардлын тооцооны авлагын үлдэгдэл 34,292.9 мянган төгрөг ба авлагын тооцоог хийж баталгаажуулаагүй, барагдуулаагүй олон жил дамжсан байна. | 34,292.90 | Албан шаардлага өгөх | Санхүүгийн албаны дарга | Г.Хунзаяа |
| 3 | Батлагдсан төсвийг ангилалаас зөрүүлэн зарцуулсан байна. | 0.00 | Зөвлөмж өгөх | Санхүүгийн албаны дарга | Г.Хунзаяа |
| | **Дүн** | 65,428.9 | | | |